



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/520

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4/в/, 29.2 дахь заалт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны IV хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчийн бүртгэлтэй Гэр бүлийн ордны дотор сантехникийн тоног төхөөрөмжийн засвар, 17 дугаар цэцэрлэгийн барилгын хүзүүвчний дээвэр засвар, 24 дүгээр цэцэрлэгийн барилгын дотор халаалтын шугамын засвар, 6 дугаар хорооллын 20 дугаар байрны гадна ариутгах татуургын шугамд гэмтэл гарсныг засварлаж хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх ажилд шаардагдах 23485069 /Хорин гурван сая дөрвөн зуун наян таван мянга жаран есөн/ төгрөгийг Болзошгүй аваарын зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг /-т зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хотын захирагчийн алба /н.Түмэнжаргал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
09 дүгээр сарын 11-ны өдрийн
520 дугаар захирамжийн хавсралт



**БАРИЛГА, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗАСВАРЫН
АЖЛЫН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ**

№	Зардлын нэр	Зардал / төгрөг/
1	24-р цэцэрлэгийн халаалтын шугамын хэсэгчилсэн засвар	7 179 930
2	17-р цэцэрлэгийн хүзүүвчний дээвэр засварлах	13 452 911
3	Орон сууцны 6-р хорооллын 20-р байрны ариутгах татуургын шугамыг засварлах	1 422 228
4	Гэр бүлийн ордны доторх сантехникийн тоног төхөөрөмжийг солих	1 430 000
	Дүн	23 485 069